



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/334

Мандалговь

2021 оны цэргийн бүртгэл явуулах
тухай

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 4.4 дүгээр зүйл, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан "Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам"-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2021 оны Цэргийн бүртгэл явуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:	Ш.Гансүх	(Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
Нарийн бичгийн дарга:	Г.Цэрэндолгор	(Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)
Гишүүд:	Ц.Баттулга	(Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, дэд хурандаа)

Сумдын Засаг дарга нар

Хоёр. Аймгийн хугацаат цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэй иргэдийн бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 04-нөөс 1 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулж явуулахыг аймгийн комиссын дарга (дэд хурандаа Ш.Гансүх) сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг хязгаарлах, хавьтлыг бүрэн тогтоох, хянах, улсын хэмжээнд тархахаас сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж байгаатай холбогдуулан олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарласан тул ариутгал, халдваргүйжүүлэлтийн горимыг чанд сахиж, улсын болон аймгийн онцгой комиссын шийдвэртэй нягт уялдуулан бэлтгэл ажлыг ханган аль болох олон хүн цуглуулахгүйгээр цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулсугай.

Дөрөв. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

1. Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан "Улсын дайчилгааны төлөвлөгөө" болон "Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч техникээр хангах төлөвлөгөө" "Сумдын орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар (хүнс болон эд хэрэгслийн тооцоо) цэргийн дайчилгааны даалгавар, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэн тоолж даалгаваржуулах;

2. Цэргийн тоо бүртгэлийн мэдээ, тайлангуудыг 2020 оны 1 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд хавсралт дахь хувиарын дагуу Монгол Улсын "Төрийн болон албаны нууцын тухай хууль" Засгийн газрын 2017 оны 246 дугаар журмын дагуу нууцлан дэвтэрлэн (эхийг файлаар авчрах) авчрах.

482011159

3. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан "Батлан хамгаалах"-ын багц хууль, 2018 онд батлагдсан "Орон нутгийн хамгаалалтын тухай хууль" Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг биеэр хаах журам" мөн тус оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн гэрээт алба хаах журам" зэрэг бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай, цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах;

4. Цэргийн бүртгэлийн зөрчилтэй, завсардагчид болон урд онуудын болон энэ оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаас зайлсхийсэн, хамрагдаагүй цэргийн үүрэгтнүүдийг эрэн сурвалжлах, бүртгэлд хамруулах ажилд Цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл мэдээллийн ажилтнууд болон холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах, тоо бүртгэлийн журам зөрчигчдийн нэрсийн жагсаалтыг гарган хэнд, ямар арга хэмжээ авсан тухай мэдээг заасан хугацаанд Цэргийн штабт ирүүлэх.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 31-ны өдрийн 1/24-т
захирамжийн хавсралт

ЦЭРГИЙН ШТАБТ ТОО БҮРТГЭЛИЙН МЭДЭЭ,
ТАЙЛАНГ ӨГӨХ ХУГАЦАА

Дд	Сумд	Тайлан өгөх хугацаа	Тайлбар
1	Говь-Угтаал	2021.01.25-ний 09.00 цагт	
2	Цагаандэлгэр	2021.01.25-ний 09.00 цагт	
3	Баянжаргалан	2021.01.25-ний 09.00 цагт	
4	Өндөршил	2021.01.25-ний 09.00 цагт	
5	Өлзийт	2021.01.25-ний 09.00 цагт	
6	Хулд	2021.01.27-ний 09.00 цагт	
7	Дэлгэрхангай	2021.01.27-ний 09.00 цагт	
8	Сайхан-Овоо	2021.01.27-ний 09.00 цагт	
9	Эрдэнэдалай	2021.01.27-ний 09.00 цагт	
10	Адаацаг	2021.01.27-ний 09.00 цагт	
11	Дэлгэрцогт	2021.01.29-ний 09.00 цагт	
12	Дэрэн	2021.01.29-ний 09.00 цагт	
13	Луус	2021.01.29-ний 09.00 цагт	
14	Гурвансайхан	2021.01.29-ний 09.00 цагт	
15	Сайнцагаан	2021.01.29-ний 09.00 цагт	